

## **ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл шаардлага:**

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна.

#### **1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын 5.2.1.3 дахь хэсэгт жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхээр, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.48.2-д “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах”, УИХ-ын 2017 оны “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтын 186-д “Жижиг, дунд үйлдвэрийн тухай /шинэчилсэн найруулга/-ыг боловсруулахаар тус тус заасан нь хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

#### **1.2. Практик үндэслэл, шаардлага**

Хууль зүйн яамны “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийн талаарх судалгааны тайлан”-д тусгагдсан хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах тухай дүгнэлттэй уялдуулан зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулна. Эдийн засаг эрчимтэй хөгжиж, зах зээлийн харилцаа гүнзгийрэхийн хэрээр одоогийн мөрдөгдөж байгаа Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг шинэчлэн найруулах, зарим зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага гарч байна.

Тухайлбал:

##### **1.2.1. Хуулийн нэрийг өөрчлөх**

Бизнесийн олон төрөлт үйл ажиллагааны чиглэл бүрэлдэн хөгжиж байгаа тул одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн нэрийг оновчтой болгох шаардлага байна.

##### **1.2.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангиллыг тодорхой болгон шинэчлэх**

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулиар гарааны болон бичил бизнес эрхлэгч, жижиг, дунд аж ахуй эрхлэгчийг тодорхойлох, ангилах асуудлыг тусгайлан зохицуулаагүй байна. Нэр томъёоны өөрчлөлтийг тодорхой болгосноор төрөөс үзүүлж буй дэмжлэгийг гарааны, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд ангиллын дагуу оновчтой хуваарилах боломж бүрдэн, улмаар бичлээс жижиг, жижгээс дунд, дундаас томоохон үйлдвэр, үйлчилгээ эрхлэлт рүү шилжих замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн өрсөлдөх чадвар, үйлдвэрүүдийн хоршин ажиллах чадвар буюу үйлдвэрүүд кластераар хөгжих, нэмүү өртгийн сүлжээнд оролцогсдын тоо нэмэгдэхээс гадна үйл ажиллагаагаа өргөтгөх идэвх санаачилга

бий болно. Хуулийн төсөлд бизнес эрхлэгчдийг дараах байдлаар ангилахаар тусгаж байна. Үүнд:

- Гарааны бизнес /стартап/
- Бичил бизнес эрхлэгч
- Жижиг бизнес эрхлэгч
- Дунд бизнес эрхлэгч

### **1.2.3. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийг оновчтой болгох**

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулинд үндсэн чиглэл, төрөөс баримтлах бодлогыг тусгасан тунхаглалын шинжтэй заалтууд хуулийн гуравны нэгтэй тэнцэж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй гэх гол шалтгаан болж байна.

Бизнес эрхлэлтийг дэмжих хүрээнд татварын таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөл, мэдээллийн хүртээмж, сургалт, зөвлөгөөний цар хүрээг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй шуурхай болгох, үйлдвэрлэл технологийн төв байгуулах, бизнес эрхлэгчид зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авах зайлшгүй шаардлага үүсэж байна. Иймд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хуулийн төсөлд оруулах, тухайлбал ажил олгогч нарыг ажлын байр шинээр бий болгох сонирхлыг эдийн засгийн хөшүүрэг ашиглан нэмэгдүүлж, ажилчдын тоо нэмэгдэх тусам ажил олгогчдын төлөх татвар, шимтгэлийн хэмжээг шатлан бууруулдаг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах, гарааны болон бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч ангилал тус бүрт дэмжлэгийн хэлбэрийг оновчтой тогтоох шаардлагатай байна.

### **1.2.4. Жижиг, дунд үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлэх:**

Орон нутгийн онцлог, ажиллах хүч, түүхий эдийн нөөцөд тулгуурлан хөгжүүлэх, орон нутагт бизнес эрхлэх санаачлагыг дэмжихэд тухайн бүс нутгийг төрөлжүүлэн хөгжүүлэх нэн шаардлагатай байна. Олон улсын туршлагаас харахад Япон улсад “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн”, БНСУ-д “Шинэ тосгон” хөдөлгөөн өрнүүлж, БНХАУ-д “Нэг сум-Нэг эрдэнэс-Нэг салбар” буюу тухайн төвлөрсөн хот сууринг үйл ажиллагааны салбар, чиглэлээр тавилга, шил үйлдвэрлэлийн гэх мэтээр төрөлжүүлэн хөгжүүлж байгаа нь маш оновчтой байна. Иймд жижиг, дунд үйлдвэрийг нэмүү өртөг шингэсэн, кластераар хөгжүүлэх бодлогыг тус хуулинд тусгах шаардлага үүсч байна.

### **1.2.5. Жижиг, дунд үйлдвэрийн салбарын бодлогыг хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалт, уялдаа холбоог сайжруулах**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны тайлангаар Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих төрийн захиргааны байгууллага нь тогтворгүй, бүтцийн болоод чиг үүргийн хувьд богино хугацааны давтамжтай өөрчлөгдөж байгаа нь энэ талаарх бодлого хангалтгүй хэрэгжихэд хүрч байна гэж дүгнэсэн.

Жижиг, дунд үйлдвэрийн газар /агентлаг/-ыг 2012 онд татан буулгасан нь Монгол улсад хөдөлмөр эрхэлж байгаа нийт иргэдийн 60 гаруй хувийг бүрдүүлж байгаа жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаагаар хамтран бүсчлэн хөгжих, зөвлөгөө, мэдээллээр хангагдах, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлэх зэрэг олон чухал бодлого,

хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангаж, бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжийг ихээр хязгаарлаж байна.

Салбарын тусгай сангууд нь тус тусдаа удирдлагатай өөр өөр чиг үүргийн яамдуудад харьяалагдаж буй одоогийн бүтэц нь нэгдсэн нэг бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, сангийн хөрөнгө зорилтод бүлэгт хүрч байгаа эсэхийг хянах боломж хязгаарлагдмал байна. Иймд бүтцийг нэгтгэн тэнд ажиллаж байгаа албан хаагчдын цалингийн сан дээр үндэслэн улсын төсөвт бага ачаалал үүсгэх байдлаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг жижиг, дунд үйлдвэрийн газрыг байгуулах эрх зүйн үндэслэлийг хуулийн төсөлд тусгана. Харин агентлаг байгуулах зохицуулалтыг төсвийн жилтэй уялдуулж 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжихээр зохицуулна.

### **Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25,1-т заасныг үндэслэн хуулийн нэр томъёог оновчтой болгох, шинээр зүйл, заалт нэмэх, нэмэлт өөрчлөлт оруулах, зарим зүйл, заалтыг хүчингүй болгох зэргээр хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэг: Хуулийн нэр томъёог олон улсад хэрэглэж заншсан, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлтүүдийг тусгана.

Хоёрдугаар бүлэг: Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилал, бүртгэлтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Гуравдугаар бүлэг: Жижиг, дунд үйлдвэрийн талаархи төрийн болон нутгийн өөрийн удирдах байгууллагын бүрэн эрхийн өөрчлөлтийн зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэг: Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн эрх үүргийн өөрчлөлтийг тусгана.

Тавдугаар бүлэг: Төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийн зохицуулалтыг тусгана.

Зургаадугаар бүлэг: Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлогын арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлтийн зохицуулалтыг тусгана.

Долоодугаар бүлэг: Бусад зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, байгууллага, албан тушаалтны эрх үүрэг зэрэг зохицуулалтыг тусгана.

### **Гурав. Хууль батлагдсанаар гарч болох нийгэм эдийн засаг, хууль зүйн үр дагавар, гарах үр дүнгийн талаар:**

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна.

Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн байгууллагын бүрэн эрх, эрхлэх асуудал, чиг үүрэг зохистой түвшинд хүрч, үндсэн чиг үүргээ хараат бус байдлаар бие даан хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэнээр хуулийн хэрэгжилт сайжирна.

Гарааны болон бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ойлголтыг тодорхой болгосноор төрөөс үзүүлж буй дэмжлэгийг гарааны, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд ангиллын дагуу оновчтой хуваарилах боломж бүрдэн, улмаар бичлээс жижиг, жижгээс дунд, дундаас томоохон үйлдвэр, үйлчилгээ эрхлэлт рүү шилжих замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн өрсөлдөх чадвар, нэмүү өртгийн сүлжээнд оролцогсдын тоо нэмэгдэхээс гадна үйл ажиллагаагаа өргөтгөх идэвх санаачилга бий болно.

Байгаль орчинд ээлтэй, өндөр болон дэвшилтэт технологи нэвтэрч, нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжинө.

Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлснээр Монгол улс дахь бизнесийн орчин сайжирч, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх мөн эдийн засгийн хөгжилд дэвшил гарч, улсын төсөвт тодорхой хэмжээний өсөлт гарах зэрэг эерэг нөлөө үзүүлнэ.

Татвар төлөгчдийн тоо нэмэгдэж улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын хэмжээ нэмэгдэнэ.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих байгууллагыг байгуулсанаар төсөвт бага хэмжээний нэмэлт ачаалал гарах боловч бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагааг бие дааж явуулах нөхцөл нь бүрдэх, удирдлагын болон боловсон хүчний мэргэшсэн тогтвортой байдал хангагдах давуу талтай юм. Улмаар эдгээр хүчин зүйлтэй уялдаж хуулийн хэрэгжилт сайжирна. Хууль батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой хэмжээний хөрөнгийг улсын төсвөөс нэмж санхүүжүүлэх шаардлагатай. Энэхүү зардлыг тусгайлан тооцож төсөлд хавсаргана.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:**

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцэж боловсруулагдана.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.